

УЛАМЖЛАЛ, ЗАН  
ЗАНШИЛ

МОНГОЛ ЗУРХАЙ БА  
ТӨМӨР МОРИН ЖИЛ

Л. Тэрбиш

Монголчууд нэн эртнээс эхлэн уул хангай, говь цөл хосолсон өргөн уудам нутагтаа нүүдлийн мал аж ахуйг хөтөлсөөр ирсэн билээ.

Нүүдэлчин монголчуудын хуримтлуулсан хамгийн анхны мэдлэг ухаан нь одзүй болон байгалийн тухай мэдлэг юм. Монгол нутагт амьдарч байсан эртний улсууд одзүйн зохих мэдлэгтэй байжээ.

Монгол туургатан нутаг сэлгэн нүүдэллэж, мал аж ахуйг эрхлэн хөтлөх явцдаа нар, сар, од, гаригийн орчил хөдөлгөөнийг анхааран ажиглаж, байгаль, цаг уурын элдэв хэмнэлт үзэгдлүүд тэдгээртэй нэн чухал холбоотойг олж мэдсэн байна. Тухайлбал, нарны хөдөлгөөн байрлалтай уялдуулан нэгэн жилийг хорин дөрвөн улирал болгон хувааж, улирал тус бүрд болох байгаль, цаг уурын нэн тогтвортой шинж чанаруудыг нээн илрүүлсэн байна. Чингээд аж ахуйн бүхий л үйл ажиллагаагаа эдгээр улирлуудад тохируулсаар иржээ. Хавар, зун, намар, өвлийн амьсгал орох улирлуудад хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөндөө бууж, тариалангийн хур буух хэмээх улиралд үр тариагаа тарьж өчүүхэн дүүрэн хэмээх улирлаас эхлэн сөл хөөн нутаг сэлгэн нүүдэллэж, малаа таргалуулан, ханш нээх улиралд морьд болон сувай гүүний дэлийг авч, үрээдийг хөнгөлөх ба ханш нээснээс хойш хонины хашаа хороонд засвар хийж, өтөг бууцыг малтах, ямааны ноолуурыг самнах ажлыг эхлэдэг. Харин сор ноолуур нь хөдөлсөн тул үслэг ан амьтныг агнах явдлыг хатуу хориглох жишээтэй.

Монголчуудын одзүйн мэдлэг нь хөрш зэргэлдээх нангиад болон эртний соёлт энэтхэг, төвд зэрэг орны ард түмний одзүйн мэдлэгтэй нягт холбоотой юм.

Бурханы шашинт улс орнуудад үүсч хөгжсөн уламжлалт одзүйг зурхай хэмээн нэрийдэх бөгөөд эл ухаан нэн эртний түүхтэй юм.

Зурхайг цагаан ба хар хэмээн хоёр ангилж болно. Цагаан зурхай дотор нь одон зурхай ба шар зурхай гэж хоёр хувааж болно. Одон зурхай нь энэтхэг, төвд, монгол орнуудад дэлгэрчээ. Харин шар зурхай нь хятад, солонгос, япон, кампучи зэрэг оронд дэлгэрсэн байна. Цагаан зурхайн онолын эх зохиол бол «Калачакра тантараража» судар бөгөөд эл зохиолыг монголоор «Цагийн Хүрдэний язгуур үндэс» гэж нэрлэнэ.

Энэ номыг анх бурхан Будда Даваасамбуу тэргүүтэй Шамбалын орны хаадад Балдан Брайбүн суварганд номлосныг энэтхэгийн мэргэн бандида Зилүба (IX зуун) шамбалд очсон худалдаачнаас дам сонсон цээжилж ирээд энэтхэг оронд дэлгэрүүлсэн гэдэг домогтой боловч эл ном (Энэ ном Ганжуурын тантарын аймгийн анхдугаар ботид буй) дахь одон (цагаан) зурхайн онолын хэсгийг задлан шинжилхүл зурхайн тооцооллын эх нь нэлээд хожуу, бүр тодруулбал манай он тооллын 806 онд тавигдсан нь мэдэгдэж байна.<sup>1</sup> Тиймээс эл зохиол Буддагийн үед бус харин есдүгээр зууны үед энэтхэгт зохиогдсон нь мэдэгдэж байна. Зохиогч нь Зилүба бандида байж болно.

**Л. Тэрбиш** - Философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

<sup>1</sup> Зохиогчийн ОУМЭ-ийн V их хуралд тавьсан «Калачакрын сургаал монгол оронд үүсч хөгжсөн түүхэн тойм» хэмээх илтгэлд үзнэ үү.

Энэтхэгт төгс боловсорсон цагаан зурхайн онолын гол ном судруудыг равжүн<sup>2</sup> хэмээх гал туулай жил (1027 он) төвд орчуулан хэрэглэж эл жилийг жарны тооллын эх болгожээ.

«Калачакратантараража» сударт нар, сар, таван гариг, (Ангараг, Буд, Бархасбадь, Сугар, Санчир) хөдөлгөөн байршлыг тооцоолон бодох аргын үндэслэл тавигдсан байна.

Чингээд дээрх ном зохиолуудад нэмэлт тайлбар хийх тооцооллын эхийг ойртуулан саах, эрхсийн хөдөлгөөн байрлалыг тооцоолон бодох аргыг нутгийнхаа хуваариудад тохируулан засварлах зэргээр ном бүтээл туурвисан төвд хүмүүс ч гарчээ. Эдгээрээс цөөн төдийг дурдвал, тавдугаар жарны шороон морин жил (1318 он) гармаба<sup>3</sup> Ранжүн дорж (1284 - 1338 он) «Бүхнийг хураасан зурхай» хэмээх онолын томоохон бүтээл туурвижээ. VII жарны шороон тахиа жил (1429 он) Цүрпүва Төвд орны газрын хуваарьт гаригийн хөдөлгөөнийг тооцоолон бодох аргыг шинээр боловсруулжээ. VIII жарны гал туулай жил (1447 он) пүгва Лхүндэвжамц «Цагаан лянхуан амны иш» хэмээх зурхайн гол судрыг зохиож төвдийн Цүр, Пүг ёсны сургууль буй болох үндсийг тавьцгаажээ.

1206 онд Монголын нэгдсэн Улс байгуулагдаж, тус улсын гадаад харилцаа өргөжин тэлж, бурханы шашны нөлөө бүхий эрдэмтэн лам нарыг удаа дараа залж байв. Тухайлбал, Хубилай хаан 1260 оноос эхлэн төвдийн Пагва лам Лодойжанцанг улсын багш болгон өргөмжилж, бурханы шашинг төрийн ёсны шашин болгох зарлиг буулгаж байсан (1, 196), мөн Мөнх хааны үед Гармава багш гэж алдаршсан Чойжин (1202-1283 он) лам хааны ордонд залагдан Пагва ламтай нэг хэсэг зэрэгцэн тахигдаж, Гармабын их лам Гармава Ролбийдорж (1339— 1383) Тогоон Төмөр хааны үед залагдаж, ордны их нөлөөтэй лам нарын нэг болсон байжээ.

Ийнхүү монголын ноёлогч ангид бурханы шашны нөлөө ихэссэн явдал шашны бүрхэвчтэй буддын мэдлэг ухааны салбарууд, тэдгээрийн нэгэн болон одон зурхайн ухаан монголд дэлгэрэх таатай нөхцөл болсон буюу. Бас дээр зохиолыг нь дурдсан эрдэмтэн лам Гармава Ранжүндорж (1284—1338) 1331 онд монголд залагдаж байсан (3.3236) нь санамсаргүй хэрэг бус зурхай дэлгэрэхэд нөлөөлсөн байж болно.

Бидэнд мэдэгдэж байгаагаар одон зурхайн талаар дорвитой бүтээл туурвисан анхны монгол хүн бол Ламын гэгээн гэж алдаршсан, анхны хүрээ ханбо Лувсанданзанжанцан (1639—1704) юм. Тэрээр арван хоёрдугаар жарны гал туулай жил (1687 он) «Зурхайн гол судар авч, ороорохыг тодотгогч гэрэл», «Бүтээлийн зурхай тэргүүтний гарын авлага» зэрэг зохиолоо бичиж, монгол оронд одон зурхай дэлгэрэх баттай суурийг тавьсан байна.

XIII жарны гал туулай жил (1747 он) монголын түүхч, гүн ухаантан, зурхайч Сүмбэ хамба Ишбалжир (1704—1788 он) төвдөд дэлгэрсэн Цүр, Пүг хоёр ёсыг Монгол орны газрын хуваарьд тохируулан «Төгс буянт шинэ зурхай» хэмээх монгол одон зурхайн шинэ сургуулийг үүсгэсэн байна. Ийнхүү монголчууд өөрийн гэж баримтлах монгол зурхайн сургуультай болжээ. Энэ ёсыг баримталж, Цахар гэвш Лувсанчүлтэм (1740 — 1810 он), Сэрдэг гэгээн Лувсанчүлтэмжамц (1865-1915 он), Говь түшээ гүний хошууны Доёдбалдан (1860 — 1920 он) нарын зэрэг хүмүүс тус бүр нэгэн боть зурхайн ном зохиож,

<sup>2</sup> Равжүн- машинд гарсан хэмээх үг гал туулай жилийн ёгт нэр бөгөөд жаран гэсэн шилжмэл утгатай,

<sup>3</sup> Гармава гэдэг нь төвдийн Цүрпүва хийдэд төвлөрч байсан бурхны нэгэн үрсгалын нэр

монгол орны өргөн уудам нутагт зурхайн шинэ ёс түгэн дэлгэрчээ.

Улмаар Их Хүрээнд 1789 онд «Зурхай дацан» хэмээх нэртэй мэргэжлийн зурхайч нарыг бэлтгэн гаргах зурхайн сургууль байгуулагдсан ба монголын томоохон хүрээ хийдүүдэд ч зурхай дадангууд байгуулагдсаар байжээ. Зурхайн талаархи онолын номуудад гүнзгий мэргэжиж, «Зийрэмбийн дамжаа» хэмээх номын хурал маргаанд оролцож амжилттай шүүлгэсэн хүмүүст «Зийрэмба» буюу «зурхайн зэрэгтэн» хэмээх эрдмийн цол хүртээдэг байжээ.

Монголын зурхайч, зийрэмба нар зурхайн талаар онолын болон од эрхсийн хөдөлгөөнийг хөөн бодох аргыг боловсруулсан ном бүтээлийг олноор туурвисан байна. Эл ном зохиолуудад тулгуурлан эрхсийн хөдөлгөөнийг тооцоолж, түүндээ түшиглэн цаг улирлын тооллын бичгийг зохиож, амьдрал ахуйдаа хэрэглэсээр иржээ.

Монгол, төвд, энэтхэгийн цаг тооллын бичгийг лит гэж нэрлэх ба нангиад зэрэг орныхыг хуанли хэмээмүй. Литүүд нь тухайн улс орны одзүй, цаг уурын мэдлэг хэр зэрэг байсныг харуулахаас гадна түүхийн мэдээ баримтуудыг ч агуулсан байдаг, энэ талаар судлаач Х. Лувсанбалдан «Тод үсэг түүний дурсгалууд» номондоо цухас дурдсан буй.

Монголын уламжлалт цаг тооллын бичгүүдийн шашны зурхай хэмээх оршилын хэсэгт лит зохиогч нь өөрийн орон нутагт болж өнгөрсөн төр, шашны гол хэрэг явдлууд, сүм хийдүүдийн (өөрийн нутгийн) товч намтар, ном зохиолын (тухайн хийдийн лам хуврагуудын зохиосон) товч мэдээг бичиж тэмдэглэсэн байдаг. Чингээд чинагш тухайн нар, сар таван гариг аль солбицолд хэрхэн харагдах, нар, сарны хиртэлт хэдийд болох зэрэг одзүйн холбогдол бүхий зүйлсийг тэмдэглэхээс гадна жилийн хорин дөрвөн улирал, цасан чихрийн амт мэт жилийн үр гэх мэт байгаль, цаг ууртай холбогдолтой зарим мэдээллийг урьдчилан гаргаж байсан нь нэн сонирхолтой юм.

Хар зурхайг дотор нь амьдын зурхай, бэрийн зурхай, үхэгсдийн зурхай хэмээн гурав ангилж болмоор байна. Хар зурхай нь ард түмний зан үйл, шашин шүтлэг болон дорно дахины ард түмний гүн ухааны сэтгэлгээ арга билэг, таван махбодын онолоор тайлбарлагдах нэн ээдрээтэй нарийвчлан судлууштай мэдлэгийн цогц юм. Хар зурхай арга билэг, махбодын зурхай ч гэж нэрлэдэг.

Арга билгийн сургаал бол орчлон дэлхийн аливаа юмс үзэгдлийн эсрэг, тэсрэг мөртөө нэгдэлтэй жам ёсыг тайлбарладаг гүн ухааны үзэл санаа юм. Эртний монголчууд дээд тэнгэрийг амилалын үндэс арга, Дэлхий ертөнцийг тэнгэрийн илрүүлэгч билиг гэж үзэж байжээ Монголын эртний түүх ба уран зохиолын сурвалж бичгүүдэд дээд тэнгэрийг «мөнх тэнгэр» буюу «эцэг тэнгэр», дэлхий ертөнцийг «эх дэлхий» буюу «идээн эх» гэж тэмдэглэж байсан нь ч буй. Энэ нь монголчуудын дотор буй болсон арга билгийн ухагдахууны хамгийн анхны үндэс сурвалж болно.

Арга билгийн ёсыг монголчууд зурхайн ухаан, анагаах ухаануудад ч нэлээд эрт хэрэглэж иржээ. Жишээлбэл: Эртний монголчууд халуун ерөндөгөөр хүйтэн өвчнийг анагаах «Монголын төөнө» хүйтэн ерөндөгөөр халуун өвчнийг анагаах «Хүйтэн усан засал» хийгээд «Чигээн анагаалт» зэргийг нэн эртнээс хэрэглэж ирсэн юм. (4.18) Зурхайн ухаанд жил, сар, өдөр, цагийг арван хоёр амьтнаар нэрлээд хулгана, бар, луу, морь, бич, нохойг эр буюу арга, үхэр, туулай, могой, хонь, тахиа, гахайг эм буюу билэг хэмээн үздэг байна.

Арга билиг нь харилцан эсэргүйцэлдэж харилцан түшиглэж, харилцан нэмэгдэж, хасагдахаар үл баран, зохих нөхцөл харилцан ули-

ран шилждэг юм. Арга билгийн энэхүү эсрэг тэсрэгийн нэгдэлд зэрэгцэн оршиж бүхүй хоёр тал нь юуны урьд тус тусынхаа эсрэг тэсрэг талаа өөрийн оршин тогтнох үндсээ болгодог. Арга билгийн дотор бас дахин арга билиг гэж хувааж болно. Өөрөөр хэлбэл аргын дотор билиг, билгийн дотор арга байдаг. Юмс үзэгдэл ингэж хуваагдан хоёр болж, бас хуваагдаж дуусашгүй байдаг хэмээн арга билгийн сургаал үздэг байна. Жишээ татвал: Өдрийг арга, шөнийг билиг гэж хуваадаг байтал үдийн өмнийг аргын доторхи арга үдийн хойныг аргын доторхи билиг, шөнийн дээд хагасыг билгийн доторхи билиг, шөнийн доод хагасыг билгийн доторхи арга гэж хуваадаг.

Аливаа юмс үзэгдлийг таван зүйлийн бодист төрөлжүүлэн хураангуйлаад, таван зүйлийн бодисын хоорондох харилцан эсэргүүцэлдэх атлаа нэгддэг харилцан хязгаарлалцах түшиглэдэг харьцаагаар аливаа юмс үзэгдлийн хоорондох харьцаа, холбоог тайлбарлаж, улам чинагшид аливаа юмс үзэгдэл бол харилцан түшиглэлцэн, үйлдэлцэхийн дунд үүсч, хувирч, хөгжиж байдаг гэсэн хөгжил, хувьслын үзлээр ертөнцийн хөгжилт, хувиралтын жам ёсыг таних ухааныг таван махбодын онол гэнэ.

Дорнодахины таван махбодын сургаалд хоёр зүйлийн таван махбода байдаг. Үүнд: шороо, ус, гал, хий, огторгуйг одон зурхайн таван махбода гэж нэрлэн, мод, гал, шороо, төмөр, усыг хар зурхайн таван махбода гэж нэрлэнэ. Хэл шинжлэл, анагаах ухаанд одон зурхайн таван махбода, хар зурхайд хар зурхайн таван махбодыг голчлон хэрэглэж ирсэн байна.

Хар зурхайн таван махбодын сургаал бол хоёр мянга гаруй жилийн түүхтэй бөгөөд аливаа юмс үзэгдлийг мод, гал, шороо, төмөр, ус гэсэн таван махбодад төрөлжүүлэн, түүний харьцаагаар юмс үзэгдлийн холбогдлыг тайлбарлана. Хар зурхайн таван махбодад хүний биеийн махбодын бүтэц, жил, гариг ба байгалийн үзэгдлийг төрөл жүүлсэн хүснэгтээр үзүүлбэл:

махбода	мод	гал	шороо	төмөр	ус
өвөрмөц чанар улирал	өсгөх хавар	халаах зун	нийлүүлэх дөрвөн засвар	ялгах намар	норгох өвөл
зүг	дорно	өмнө	дөрвөн зовхис	өрнө	умар
жил амин	бар	могой	үхэр, луу	бич	гахай
махбода	туулай	морь	хонь, нохой	тахиа	хулгана
таван гариг	бархасбадь	ангараг	санчир	сугар	буд
өнгө	хөх	улаан	шар	цагаан	хар
цул	элэг	зүрх	дэлүү	уушиг	бөөр
сав	цөс	гэдэс	ходоод	олгой	давсаг
цулын судал	элэгний судал	зүрхний судал	дэлүүний судал	уушигны судал	бөөрний судал
савын судал	цөсний судал	гэдэсний судал	ходоодны судал	олгойн судал	давсагны судал

Хар зурхайн таван махбодын сургаалд эх, хөвгүүн, нөхөр, дайсан бололцох харьцаагаар юмс үзэгдлийн хоорондох харьцааг тайлбарладаг юм. Үүнд: Эх хөвгүүний харьцаа гэдэг нь энэ нэгэн махбода нь тэр нэгэн махбодын эх болж байвч, нөгөө нэг махбодын хөвгүүн болж, энэ мэтээр нэг махбода нь эх хөвгүүний аль нь ч болох бололцоотой юм. Жишээлбэл: Модон махбода нь усан махбодын хөвгүүн болж, харин гал махбодын эх болдог тул модны хөвгүүн гал, галын эх мод гэх мэт. Энэхүү эх, хөвгүүн бололцох харьцаанд үүсгэж, үүсгэгдэх, тэжээж тэжээгдэх, төлжүүлж төлжүүлэгдэх, зэрэг агуулга багтана.

Нөхөр дайсны харьцаа гэдэг нь энэ махбода нь тэр нэг махбодын нөхөр болж байхад бас өөр нэг махбодынхаа дайсан болох юм. Жишээлбэл: Шороо нь усан махбодын дайсан болж байхад модон махбодын нөхөр болно. Бас хоёр махбода харилцан нөхөр дайсны харьцаатай байж болно. Жишээлбэл: Шороон дайсан мод, модны нөхөр шороо гэх мэт. Энэхүү нөхөр дайсны харьцаанд харилцан түшиглэх, туслах, харилцан хязгаарлах, дайсанах, эсэргүүцэх зэрэг агуулга багтана.

Хар зурхайн таван махбодын эх, хөвгүүн, нөхөр, дайсан бололцох харьцааг томъёоллоор илэрхийлбэл: Мод, гал, шороо, төмөр, усыг дэс дараагаар нэг тойрог шугам дээр цагийн зүүн эргэлтийн чиглэлээр жагсаагаад, аль нэг махбодыг эх, хөвгүүн, нөхөр, дайсныг олъё гэвэл түүний «урдах нь эх, дараах нь хөвгүүн, гуравдах нь нөхөр, дөрөвдөх нь дайсан» болно.

Хар зурхайн таван махбодын сургаалыг анагаах ухаанд хэрэглэхдээ «Анагаах ухааны дөрвөн үндэсний хойт үндэс»-ний «Хүрэлцэх судлаар өвчнийг танин барих бүлэг»-дөрвөн улирлыг хавар-модон махбода, зун-гал, намар-төмөр, өвөл-усан махбода дэлгэрэх бөгөөд дөрвөн улирлын завсар бүр (улирал бүрийн сүүлийн арван найман хоног) шороо махбода дэлгэрнэ гэж тус тус төрөлжүүлээд, дөрвөн улирлын хувиралтад нөлөөлөгдөн үүсдэг таван цулын хувиралтыг шинжлэх, судлын лугшилтын хувиралтыг шинжлэх, таван цулын хоорондын харьцааг шинжлэхэд эх, хөвгүүн, дайсан, нөхөр болох харьцаагаар тайлбарласан байна.

Хар зурхайд ч нар, сар, жил, сар, өдөр, цагийг таван махбодоор төрөлжүүлэн хуваагаад, махбодын харьцаагаар хүн, амьтанд нөлөөлж болох хэмнэлүүдийг томъёолон гаргаад, тэдгээрийг авч, огоорох талаар тайлбар өгдөг байна.

Хар зурхайн чиглэлээр энэтхэг, төвд, монголын мэргэд олон тооны ном бүтээл туурвисаар ирсэн нь бидний үе хүртэл хадгалагдаж иржээ. Тухайлбал, монголын зурхайч «ламын гэгээний анхдугаар дүр» гэж алдаршсан Лувсанданзанжан ХШ жарны шороон могой жил (1749 он) Хатан голын хөвөөнөө хэсэг төвд шавь нарынхаа эгээрлийг ханган бичсэн «Үрийн тоо сайтар номлосон бүхний хураангуй» хэмээх номдоо:

Огторгуйд орчигч одон гариг

Орчлонгийн амьтанд сайн мууг үзүүлмүй

Огоорч, авахыг мэдүүлэхийн тулд

Үрийн зурхайг гаргавай би гэж тэмдэглэсэн нь их гүн агуулгатай байна. Чингээд зохиогч тухайн номдоо гариг эрхэс, жил сарын олон хэмнэлтийг таван махбодад төлөөлүүлж, түүнийгээ цаг уур, хүний бие махбодад хэрхэн нөлөөлөх талаар бичихүй.

Цахар гэвш Лувсанчүлтэм (1740— 1810)-ийн зохиолуудын 7-р боть нь нийтдээ зурхайн ухаанд зориулагдсан бөгөөд энэ ботийн 9-р дэв-

тэр буюу «Махбодын зурхайн ёсны жилийн тотгорыг шинжихүй увидасны утгын хураангуй» хэмээх номдоо хүмүнд эхээс мэндлэх үеийн од, гариг, нар, сарны солбилцол тодорхой үйлчилгээг үзүүлж, чанагш од, гаригийн орчил, цаг хугацааны улирах давталт тухайн хүний бие махбод, сэтгэц, оюун ухаанд зохих нөлөөллийг үзүүлнэ гэсэн үзэлт гаргаж, түүнийгээ таван махбодын сургаалаар тайлбарласан байна.

Мөн монголын эмч, Лувсанчойнпэл тойн «махбодын зурхайн нэгэн ном зохиож түүндээ «Амьтны манлай хүний бие таван махбодаар бүтсэний тулд атгаг шалтгааны эрхээр хорлогдох, жаргах, зовох нь махбодаас боломуй. Тийм тулд сайн, муу нь махбодыг тоолохуй хэрэгтэйн тулд эрдэнэ хүмүний амьдын тоолол нэг жилд эвцэлдсэнийг эргүүлэн тоолохуйг үзүүлмүй» гэж номын зорилгоо тодорхойлсон бөгөөд агуулга (номын) нь Цахар гэвшийн дээр дурдсан номынхтой тун төсөөтэй байна.

Монголчууд хар зурхайн «мэнгэ голлох» хэмээх ёс, «жил орох» хэмээх арван хоёр жилийн, «чиса гариг» хэмээх долоо хоногийн хэмнэлүүдийг ихэд анхаардаг байжээ. Аливаа ажил үйлс бүтэмж муутай болоход «мэнгэ голлосон юм боллоо » гэх нь буй.

Арван хоёр жил, таван гаригийг таван махбодад төрөлжүүлэн хуваагаад жилүүдийг гаригуудтай эх, хөвгүүн, нөхөр, дайсны харьцаагаар ялгавал (өмнөх хүснэгтэд үзнэ үү): Модон махбодатай бар, туулай жилийн дайсан нь төмөр махбодатай сугар, гал махбодатай могой, морин жилийн дайсан гариг нь усан махбодатай буд, шороон махбодатай үхэр, луу, хонь, нохой жилийн дайсан гариг нь модон махбодатай бархасбадь, төмөр махбодатай бич, тахиа жилийн дайсан гариг нь тал махбодатай ангараг, усан махбодатай гахай, хулгана жилийн дайсан гариг нь шороон махбодатай санчир гариг болохоор хүний махбода төрсөн жилийнхээ махбодатай амин холбоотой гэж хар зурхайн үзэлтээр тайлбарлаж, бар, туулай жилтэй, сугар; могой, морьтонд буд; үхэр, луу, хонь, нохой жилтэнд бархасбадь; бич тахиа жилтэнд ангараг; гахай, хулгана жилтэнд санчир гариг дайсагнана, чиса<sup>1</sup> гариг болно хэмээгээд чиса гаригтаа өдрөө элдэв муу зүйлд өртөгдөх бий гэж анхаарах болгоомжилдог байжээ.

Хар зурхайд энэ мэт байгаль, цаг уур, хүн амьтантай холбоотой олон хэмнэлүүд байдгийг манай цаг уурчид, эмч нар, биологичид, амьтан судлаачид чинагши нягтлан судламаар бодогдоно.

Монголчууд зурхайн ухаанд тулгуурлан цаг тооллын бичгийг зохиож түүндээ тухайн жил ямар өнгө байдалтай болохыг урьдчилан тэмдэглэсээр ирснийг дээр дурдсан билээ.

Монгол зурхайн ёсоор бол шарагчин могой жилд монголын нутаг нийтдээ хур бага, салхи ихтэй боловч үр тариа сайн, алив зүйлийг ухаалгаар шийдвэрлэхэд онцгой тохиромжтой байсан аж.

Ирж буй цагаан морин жилийн өнгө байдал нь:

«Машид согтонги» хэмээх төмөр морин жилд хүмүүн амьтан согтох мэт мансуур-магдуу болох авч ургац сайн, эд баялаг арвижин нийтээр амгалан тайван байна.

Төмөр морин жилийг эзлэсэн гариг нь Адъяа тул хүмүүн, мал халуунд түүртэн ядрах нь их, хүмүүн малд халуун эмгэг өвчин дэгжин хөдлөх нь амар учир биеэ болгоомжилвол ашигтай аж.

Энэ жилийн түшмэл гариг нь Сугар тул хур бороо орох нь амар, үр тариа дэлгэрэн, зундаа халуун их, эд эрдэнэс арвижихын нигууртай.

Энэ жилийн гаригийн хөдөлгөөн байрлал нь Хаврын гурван сар, Зуны эхэн, Зуны адаг, Өвлийн эхэн саруудад архаг хууч өвчтэй хү-

<sup>1</sup> Чиса нь үхэх гариг гэсэн утгатай төвд үг.

мүүс биеэ болгоомжлох, Зуны дунд, Намрын эхэн, Өвлийн эхэн ба дунд саруудад хур оромтгой, алив үйлсэд амгалан сайн, Намрын дунд болон адаг саруудад салхи шуурган ихдэж, цаг агаар муудаж болзошгүйг анхааруулж байгаа ажээ.

Мөн энэ жилийн зуны дунд сарын арван тавнаас эхлэн пагшаг (гахайн хоног гэсэн утгатай төвд үг) хэмээх одон долоо хоног гарах тул энэ үед усан эмчилгээ, усан засал хийлгэх зэрэг усны үйлийг тэвчих хэрэгтэй. Пагшаг хэмээх од гарах энэ хугацааг монголчууд «усны хор оров» хэмээн усны үйлийг ихэд тэвчдэг ажээ.

Мөн жилийн намрын тэргүүн сарын арван есөнд Рихи хэмээх од гаран ус эмчилгээний чанартай болж, сайжрах тул усан засал, усан эмчилгээнд шамдвал сайн гэж эмийн сударт өгүүлсэн байна.

Од эрхсүүд нэгэн солилцолд (дэлхийн ажиглагчаас) ойрхон харагдахыг од, эрхсийн тохиол гэнэ. Энэ тохиолуудын дотроос Гар од<sup>1</sup> сар болон Мичид<sup>2</sup> сарны тохиолыг илүү чухалчлан ажигладаг.

Энэ тохиолууд хэдийд хэрхэн харагдах хийгээд түүний шинжүүдийг зурхайн сударт бичсэнийг уншигч танаа сонирхуулан толилуулсу!

### 1. САР, ГАР ОД ХОЁРЫН ТОХИОЛ

Сар, гар од хоёрын тохиолыг өвлийн дунд сарын хорин долоон, өвлийн адаг сарын хорин таван, цагаан сарын хорин гурванд шинжиж, тэр жилийн өнгө байдлыг дараах маягаар таамаглаж байжээ.

Тохиолыг тухайн өдөр нь ажиглаж, зурагтай тулган сонирхох ажаамуй.

1. Эрхий хуруунаас доош царвуунд саран тохиовоос буян жаргалан ихтэй болох, хүн малд эмгэг бага, тариалан сайн ургах.
2. Эрхийн ёроолд саран тохиовоос мал, адгуусанд сайн. Хур бороо их орох тариаланд сайн.
3. Эрхийн бэлхүүсэнд саран тохиовол ган ихтэй жил болно.
4. Эрхийн дээд үенд саран тохиовоос ган, зуд их болно.
5. Эрхийн үзүүрт саран бууваас тэр нь «Яргачин хутга барих» хэмээх нэртэй эр хүнээс аюул их гарах, халдварт өвчин ихдэх боловч, тариаланд сайн төдий.
6. Эрхийн өмнө саран бууваас тариалан сайн болно.
7. Саран эрхий, долоовор хуруу хоёрын завсар бууваас хэл ам, хэрүүл маргаан дэгдэх муу.
8. Долоовор хуруунд саран бууваас тайжийн язгуурт ширүүн муу болох, хонь малд муу болох, тариалан сайн.
9. Саран долоовор, дунд хуруу хоёрын завсарт бууваас хур багатай тариалан дунд зэрэг авна.
10. Саран дунд хуруунд бууваас ухаантай мэргэд хийгээд номын багш нарт муу. Тариаланд гэм их, хяруу мөндөр их орох, морь тэргүүтэн битүү тууриатай амьтанд муу.
11. Саран дунд ба ядам хурууны завсарт бууваас цас их орно.
12. Саран ядам хуруунд оршивоос ган их болж, хяруу буух нь элбэг. Тариалан гэмтэнэ, хатагтай нар, илжиг, хонь, ямаа тэргүүтэнд муу.
13. Ядам хуруу, чигжийн завсар саран бууваас таних, тариалан гэмтэх боловч малд сайн.
14. Чигжий хурууны үзүүрт саран бууваас тариалан дундуур хүн мал, хонинд өвчин болно. Нялхас, өвгөд, эмгэдэд муу.
15. Саран чигжийн бэлхүүсэнд буувал хяруу их бууна.
16. Хуруун ёроолд бууваас тариалан сайн, он тарган болно.
17. Саран гарын алган дотор бууваас тариалан сайн, он тарган.

18. Түүнээс холдвоос хур ус их орно.
20. Гадаад өнцөгөнд саран буувал хур ус ихтэй болно.
21. Саран бугуйвчинд буувал нийтэд сайн. Хүнд эд мал элбэг олдох сайн.
22. Саран бугуйвчны дор буувал хотолд буянтай сайн.
23. Саран гарын дотор оршивоос хяруу мөндөр ихдэж, зуд турхан болно.
24. Алинд ч буулгүй өнгөрвөөс ямарч нөлөөгүй тэгш болно. Гар од, сар хоёрын тохиолыг «Цагаан биндэръяа» сударт ийнхүү дурджээ.

## 2. САР, МИЧИД ХОЁРЫН ТОХИОЛ

Сар, мичидийн тохиолыг монголын арван сарын арван таванд шинжлэх үйлдмүй. Үдэш арван тавны сар ургахуйд:

Саран мичидийн өрнөд тохиовоос тариалан гэмтэх хийгээд, малд гэм ирэх, хүнд өвчин болох муу.

Саран мичидийн дорнод тохиовоос салхи гаран хямрал болох муу.

Саран мичидийн өмнөд тохиовоос ган их, өвс, мод муу ургах, зуд болно.

Саран мичидийн умард тохиовоос бүх зүйл тэгшрэх машид сайн гэжээ.

Хятад, төвд, энэтхэг, монгол зэрэг орнуудад дэлгэрсэн «Шороон үхрийн шинж» хэмээх жилийн цаг уур, өнгө байдлыг шинжлэх өвөрмөгц сонин арга байжээ. Эдүгээ хятад, төвд, энэтхэгт гаргаж буй уламжлалт цаг улирлын тооллын бичгүүдэд шороон үхрийн шинжийг оруулж байгаа билээ.

Шороон үхрийн шинжийн гол агуулга нь тухайн жилийн махбода болон тэр жилийн хаврын амьсгал орох өдрийн махбодыг хооронд нь хэрэлдүүлэн тоолж, үхэр болон үхэр хариулаачны зурагт схемийг гаргаад, схемийн үр дүн болгон мөнхүү жилийн цаг уур ба өнгө байдлыг урьдчилан боддогт оршино.

Математикийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан, миний зурхайн багш агсан Б. Жинба өөрийн хувийн номын сангаасаа «Шороон үхрийг шинжих ёс сэтгэлийг огоот хураасан модны мөчир оршивай» хэмээх номыг надад хайрлаад шороон үхрийг шинжих ёсыг зааж өгсөн билээ.

Одоо энэ номоор төмөр морин жилийн шороон үхрийг шинжилж, уншигч танаа сонирхуулсу!

### **ТӨМӨР МОРИН ЖИЛИЙН ШОРООН ҮХРИЙН ШИНЖ**

XVII жарны төмөр морин жилийн улирал бүхний эхэнд бага зэргийн хуртай. Зуны дунд сард гандуу. Зэрлэг мөндөр оромтгой боловч тариа будаа сайтай, үр төл арвижихын нигуур буй.

Өвлийн эхэнд цастай. Хүүхэд болон нийт ард түмэнд ивээлтэй.

Зарим нутаг улс гүрний хооронд маргаан гарах боловч даян дэлхийд энх амгалан оршихын нигуур буй.

### **Төмөр морины жилийн улирлууд**

Хаврын тэргүүн сарын 10-ны 4 цаг 21 минутад Ичигсэд хөдлөх улирал эхлэнэ. Хаврын их салхи босно.

Хаврын тэргүүн сарын 25-ны 5 цаг 15 минутад өдөр шөнө тэнцэнэ.

Хаврын дунд сарын 11-ний 9 цаг 19 минутад Ханш нээнэ. Огторгуйн тоос арилж цэлмэнэ. Таримал мод тарих цаг. Харз ус дэлбэрнэ. Морин хараацай ирнэ.

Хаврын дунд сарын 25-ны 16 цаг 30 минутад Тариалангийн хур буух улирал эхлэнэ. Үр тариа тарихад хамгийн тохиромжтой үе. Бух цахлай тогоруу тэргүүтэн ирнэ.

Хаврын сүүл сарын 12-ны 2 цаг 49 минутад Зуны амьсгал орно. Дулаарч эхлэнэ. Хөхөө шувуу донгодож, гүн худгийн ус л хүйтэн байна. Их шар цэцэг амаа нээнэ.

Хаврын сүүл сарын 27-ны 15 цаг 56 минутад Өчүүхэн дүүрэн буюу Малын бага цадлага хэмээх улирал эхлэнэ. Сөл хөөж малаа таргалуулах үе. Нохойн хушууны цэцэг ургана.

Зуны тэргүүн сарын 13-ны 7 цаг 16 минутад Буудай боловсрох хэмээх улирал эхлэнэ. Буудайн үр хүндрэн хөхөрч эхэлнэ.

Зуны тэргүүн сарын 30-ны цаг 3 минутад зуны нар буцах улирал эхлэнэ. Ус хортой болж долоо хоног үргэлжилнэ.

Зуны дунд сарын 15-ны 17 цаг 43 минутад Бага халууны улирал эхлэнэ. Модны жимс боловсрон үндэс нь хорхойтож болзошгүй. Мал сүрэг гүйцэд цадна.

Зуны сүүл сарын 1-ний 11 цаг 12 минутад Их халууны улирал эхлэнэ. Мал ундагасах нь ихдэнэ. Хөхөөн дуу тасрана

Зуны сүүл сарын 17-ны 3 цаг 46 минутад Намрын амьсгал орно. Мөндөр орж эхлэнэ, салхи хөдөлнө.

Намрын тэргүүн сарын 3-ны 18 цаг 31 минутад Сэрүүний амьсгал орох улирал эхлэнэ. Халуун хомсдож сэрүүн болно. Хур татарч мөрөн голын ус хомсдоно.

Намрын тэргүүн сарын 19-ний 6 цаг 59 минутад Цагаан хяруу унах улирал эхлэнэ. Усны чанар сайжирна. Огторгуй цэлмэг тунгалаг сайхан байсан ч мод, өвс тэргүүтний өнгө гандан хувирна.

Намрын дунд сарын 4-ний 16 цаг 25 минутад Намрын өдөр шөнө тэнцэх улирал эхлэнэ. Усны шувууд буцна. Ургамал бүхний өнгө хувирна. Мөнх ногоон ургамал улам гойд харагдана.

Намрын дунд сарын 19-ний 22 цаг 49 минутад Хүйтэн шүүдэр буух улирал эхлэнэ. Тэнгэрийн дуу тасрана.

Намрын сүүл сарын 6-ны 1 цаг 51 минутад Хар хярууны улирал эхлэнэ. Газрын хөрс хөлдөнө. Хяруу унаж, хур цас болон хувирна.

Намрын сүүл сарын 21-ний 1 цаг 52 минутад Өвлийн амьсгал орно. Ус зайрмагтаж, хүйтний эрч сайжирна.

Өвлийн тэргүүн сарын 5-ны 23 цаг 11 минутад өчүүхэн цас унах улирал эхлэнэ. Хүйтний эрч чангарч, мал хийгээд араатан амьтны үс гүйцнэ.

Өвлийн тэргүүн сарын 21-ний 10 цаг 30 минутад Их цасны улирал эхлэнэ. Хүйтний эрч улам чангарч, ус хөлдөнө.

Өвлийн дунд сарын 5-ны 12 цагт Өвлийн нар буцах улирал эхлэнэ. Ес эхлэнэ.

Өвлийн дунд сарын 21-ний 4 цаг 58 минутад Бага хүйтний улирал эхлэнэ. Хүйтний эрч ихэд чангаран, араатан амьтан даарч ийш тийш гүйлдэнэ.

Өвлийн сүүл сарын 5-ны 22 цаг 10 минутад Их хүйтний улирал эхлэнэ. Хүйтэн туйлдаа хүрнэ. Энэ улирлын дунд үеэс хүйтний эрч үе үе суларч чангарна.

Өвлийн сүүл сарын 21-ний 16 цаг 11 минутад Хаврын амьсгал орно. Газар дороосоо гэсэж эхлэнэ. Хаврын урь орж салхины үзүүр эргэнэ.

Монгол зурхайд нэн чухал хэрэглэгддэг шар замын дагуух 28 од, монгол тооны нэрсийг хавсаргав.

<sup>1</sup> Гар од нь оддын арван хоёр ордны хамтатгахын ордны хоёр дахь од болно.

<sup>2</sup> Мичид нь Оддын арван хоёр ордны хонины ордны хоёр дахь од

<sup>1</sup> Ч. Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр Гүн ухааны сэтгэлгээ. 1987 он

<sup>2</sup> Ч. Далай, Юань гүрний үеийн монгол, 1973

<sup>3</sup> Хятад-Монгол их толь. Гуравдугаар дэвтэр

<sup>4</sup> Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь. Монгол анагаах ухаан. Дэд дэвтэр. 1986 он,

<sup>5</sup> Махбода бүхний хураангуй тодруулан үйлдсэн амьдын зурхай Лувсанчойнпэлийн зохиол, Хүрээ бар, 34 хуудас, Төвд судар.

<sup>6</sup> Үрийн тоо сайтар номлосон бүхний хураангуй. Лувсанданзанжанцангийн зохиол, гар бичмэл, төвд судар, 51 хуудас

<sup>7</sup> Цагаан биндэрьяа, төвдийн түүхч, зурхайч, эмч Санжаажамцын, зохиол, Хүрээ барын төвд судар. 634 хуудас

### МОНГОЛ ТООНЫ НЭРС

1 Дан тоо	10 <sup>33</sup> —эрхэт
10 <sup>0</sup> —нэг	10 <sup>34</sup> —их эрхэт
10 <sup>1</sup> —арав	10 <sup>35</sup> —сайтар хүрсэн
10 <sup>2</sup> —зуу	10 <sup>36</sup> —Их сайтар хүрсэн
10 <sup>3</sup> —мянга	10 <sup>37</sup> —онон одох
10 <sup>4</sup> —түм	10 <sup>38</sup> —их онон одох
10 <sup>5</sup> —бум	10 <sup>39</sup> —живэх тоосон
10 <sup>6</sup> —сая	10 <sup>40</sup> —их живэх тоосон
10 <sup>7</sup> —хүлд	10 <sup>41</sup> —бэлгэ тэмдэг
10 <sup>8</sup> —дүнчүүр	10 <sup>42</sup> —их бэлгэ тэмдэг
2 Давхар тоо	10 <sup>43</sup> —хүчин нөхөр
10 <sup>9</sup> —тэр бум	10 <sup>44</sup> —их хүчин нөхөр
10 <sup>10</sup> —их тэр бум	10 <sup>45</sup> —дохио мэдэх
10 <sup>11</sup> —наяд	10 <sup>46</sup> —их дохио мэдэх
10 <sup>12</sup> —их тэр бум	10 <sup>47</sup> —тийн болсон
10 <sup>13</sup> —маш дэлгэмэл	10 <sup>48</sup> —их тийн болсон
10 <sup>14</sup> —их маш дэлгэмэл	10 <sup>49</sup> —хүчин нүдэн
10 <sup>15</sup> —тунамал	10 <sup>50</sup> —их хүчин нүдэн
10 <sup>16</sup> —их тунамал	10 <sup>51</sup> —асрахуй
10 <sup>17</sup> —ингүмэл	10 <sup>52</sup> —их асрахуй
10 <sup>18</sup> —их ингүмэл	10 <sup>53</sup> —нигүүлсэхүй
10 <sup>19</sup> —хямралгүй	10 <sup>54</sup> —их нигүүлсэхүй
10 <sup>20</sup> —их хямралгүй	10 <sup>55</sup> —баясахуй
10 <sup>21</sup> —ялгаруулагч	10 <sup>56</sup> —их баясахуй
10 <sup>22</sup> —их ялгаруулагч	10 <sup>57</sup> —тэгш
10 <sup>23</sup> —өвөр дээр	10 <sup>58</sup> —их тэгш
10 <sup>24</sup> —их өвөр дээр	3 Их тоо
10 <sup>25</sup> —хөөн одогч	10 <sup>59</sup> —тоолшгүй
10 <sup>26</sup> —их хөөн одогч	10 <sup>60</sup> —хэмжээлшгүй
10 <sup>27</sup> —хязгаар үзэгдэл	10 <sup>61</sup> —цаглашгүй
10 <sup>28</sup> —их хязгаар үзэгдэл	10 <sup>62</sup> —өгүүлшгүй
10 <sup>29</sup> —шалтгаан зүйл	10 <sup>63</sup> —хэрлэшгүй
10 <sup>30</sup> —их шалтгаан зүйл	10 <sup>64</sup> —үлэшгүй
10 <sup>31</sup> —үзэсгэлэн гэрэлт	10 <sup>65</sup> —үлж дуусашгүй
10 <sup>32</sup> —их үзэсгэлэнт гэрэлт	10 <sup>66</sup> —сэтгэшгүй

<b>Монгол нэр</b>	<b>ХОРИН НАЙМАН ОД Санскрит нэр</b>	<b>Төвд нэр</b>
1. Гоё хүүхэн	Барани	Бранэ
2. 6 эхтэй хүү	Гирдиг	Мэндүг
3. Чөлөөт эх	Ровагини	Нарма
4. Гөрөөсөн толгой	Мэргэшир	Го
5. Хэрцгий охин	Артир	Лаг
6. Өглөгт охин	Бурнаवासан	Навсо
7. Найралт эх	Бүс	Жал
8. Үнэг	Аслис	Гаг
9. Их морь	Мэг	Чү
10. Бага морь	Бурвабэлгүни	Дэ
11. Харцага	Удирабэлгүни	Бо
12. Түүхчин	Хасда	Мэши
13. Тэргүүн дагуул	Цэдэр	Нагва
14. Салхины эх	Сувади	Сарий
15. Эрхтийн тэнгэр	Шошаг	Сага
16. Гар од	Анурад	Лхамцам
17. Хонгорцог	Цэсда	Нрон
18. Онгоц	Мол	Нрүв
19. Суулга	Бурвасад	Чүдод
20. Элдэв тэнгэртэн	Ударасад	Чүмад
21. Яруу эгшигт	Аоизи	Дошин
22. Булаагч	Ширван	Жишин
23. Тооно	Даниста	Мондэ
24. Чөдөр	Садабис	Мондү
25. Шувуун хушуут	Бурвабадрабад	Түмдод
26. Могойг хүлэгч	Ударабадрабад	Түммад
27. Дэлгэрүүлэгч	Ривади	Намдү
28. Шийдэм	Ашувани	Тагар

**МОНГОЛЫН  
УЛАМЖЛАЛТ  
АНАГААХ УХААН**

**Б. Болдсайхан**

Эртний түүхийн сурвалж бичиг дэх Монгол нутагт оршин тогтнож байсан аймаг угсаатны анагаах арга заслын тухай зарим баримт сэлтээс Монголчууд эрт дээр цагаас ардын эмнэлгийн зохих мэдлэгтэй байсныг олж мэдэж болох юм.

МЭӨ Ш—П зууны үед БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан Хүннү улсын үед төөнө тавих эмчилгээг анх түрүү бий болгон түүнийг Хятадууд авч хэрэглэсэн тухай МЭӨ П зууны орчим бичигдсэн эртний хятадын анагаах ухааны «Нэй зин» номонд дурьдсан тухай мэдээ бий.<sup>1</sup>